



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/185

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын төвийн дээд өргөн чөлөөнд 900 метр асфальтан зам тавих ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)
О.Түвшинжаргал (Цагдаа, зохицуулагч)

2. Ажлын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН